

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль
2020.12.31

Дагаж мөрдөх огноо:

21 03 10

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

21 03 10

Байгууллагын нэр:

Гадаадын иргэн, харьяатын газар

Нэгжийн нэр:

Хангальт, үйлчилгээний хэлтэс

/Агентлагийн даргын 2021.03.10-ны өдрийн A/48 дугаар тушаалаар өөрчлөлт орсон/

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Жолооч

Төрийн үйлчилгээ, ТҮ-3

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа дэнж, Гадаадын
иргэн, харьяатын газрын төв байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эзэмшиж буй автомашины техникийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хариуцах,
зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг
хангах, өдөр тутмын үйл ажиллагаанд автомашинаар үйлчлэх, үр дүнг хэлтсийн даргын
өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрэмд заасан жолоочийн үүрэг хүлээх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, өдөр тутам автомашин жолоодон үйлчлэх;
- 2.Автомашины аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, хариуцсан тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоо, засвар үйлчилгээнд хуваарийн дагуу оруулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм жurmыг мөрдөж ажиллах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийг баримтлан замын хөдөлгөөнд оролцох;	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг биелүүлж ажилласан байна.	Г
	2.Шууд удирдах албан тушаалтнаас ажил үүрэгтэй нь холбоотой өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, тайлагнах;	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэсэн байна.	Г
	3.Байгууллагын даргын тушаалаар баталсан автомашин ашиглах журмыг чанд мөрдөх;	Холбогдох дүрэм, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдсөн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Албан ажлын хэрэгцээнд автомашины үйлчилгээ үзүүлэх;	Өдөр тутмын үйл ажиллагаанд автомашинаар түргэн шуурхай үйлчилсэн байна.	Г
	2.Өдөр тутмын үйлчилгээнд гарсан автомашины замын хуудсыг цаг тухайд нь бүртгэж гарын үсгээр баталгаажуулах, үнэт цаас, талон, шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн захиалга өгч, зарцуулалтын тооцоог тогтоосон журмын дагуу хийх;	Холбогдох журмын дагуу хугацаанд нь тооцоог хийсэн байна.	Г
	3.Хариуцсан техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, автомашиндаа цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх;	Эвдрэлтэй эд ангид мэргэжлийн дүгнэлт гарган, засвар үйлчилгээг гэрээт байгууллагаас хийлгүүлсэн байна.	Г
	4.Техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээг хийх;	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.	Г

ГАИЛДЫН ИРГЭН, ХАРЬЛАТИН ГАЗУУ


ЭХ ХУВЬ^{2021.09.14/8} оны^{14/8} тогтоо,

ТУШААЛ

	5.Хариуцсан автомшинаа гражид тавих, авах, гражын эмх цэгц, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг сахих.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг сахиж ажилласан байна.	Г
	6.Байгууллагын засвар үйлчилгээ, тохижилт, зохион байгуулах арга хэмжээний засал чимэглэл хийх ажилд оролцох;	Холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г
Бусад үйл ажиллагаа	1.Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Архивын тухай хууль, байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам" болон бусад эрх зүйн актыг мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Г
	2.Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлэх;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Г
	3.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх;	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандaa мөрдөн зөрчил, дутагдал гаргалгүй ажилласан байна.	Г
	4.Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж ажилласан байна.	Г
	5.Өөрийн ажлыг хөдөлмөрийн болон бусад гэрээний дагуу хэрэгжүүлэх, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гарган холбогдох мэргэжилтэнд өгөх;	Хөдөлмөрийн болон бусад гэрээ хэрэгжсэн, гүйцэтгэлийг тайлагнасан байна.	Г
	6.Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.	Арга хэмжээнд оролцсон байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсролтой байх.		
Мэргэжил	-“В” ангиллын жолоодох эрхийн үнэмлэхтэй байх.		
Мэргэшил	- Мэргэшсэн жолоочийн гэрчилгээтэй байх.		
Туршлага	- Цэргийн алба хаасан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- автомшины эвдрэл гэмтлийг оношлох чадвартай байх;	- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх;



	Асуудал шийдвэрлэх	- албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх;
	Багаар ажиллах	- ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх;
	Бусад	- ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Гадаадын иргэн, харьяатын газрын дарга, Дэд дарга, Хангарт, үйлчилгээний хэлтсийн дарга, аж ахуйн менежер, авто механикч.

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> Нийт:	<u>Бусад харилцах субъект</u> 1.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.
---	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.ДАВААНЯМ

2021 оны дугаар сарын 10-ны өдөр

1116126983 2712253

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:


ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: **21 03 10**


Дугаар: **A/48**

(тамга/тэмдэг)

Агентлагийн дарга



..... Н.УУГАНБАЯР



тушаал